




Үйлчилгээний Нөхцөл



Нэмэлт, Өөрчлөлт

Он,сар, өдөр	Зүйл, заалт	Өөрчлөлт	Хувилбар
2025.08.01		Шинэчилсэн найруулга	1.0

ҮЙЛЧИЛГЭЭНИЙ НӨХЦӨЛ**НЭГ.НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ**

- 1.1. Энэхүү “Үйлчилгээний нөхцөл” /цаашид “**Нөхцөл**” гэх/-ийн зорилт нь үйлчилгээ үзүүлэгч “**АйТрейдер Финтек**” ХХК болон олон улсын зах зээлийн форекс арилжаанд оролцох, өндөр дүнтэй арилжааны дансыг удирдах, мэргэжлийн арилжаачин болох хүсэлтэй, энэхүү нөхцөлтэй танилцсан, хүлээн зөвшөөрсөн иргэн /цаашид “**Хэрэглэгч**” гэх/ нарын хооронд байгуулагдсан “**Хэрэглэгчийн үйлчилгээний гэрээ**”-гээр зохицуулагдаагүй харилцааг зохицуулахад оршино.
- 1.2. Үйлчилгээ үзүүлэгч нь эрсдэл мөнгөний менежментийн дүрмүүдийг сайн баримталдаг, ашигтай арилжих мэргэжлийн арилжаачдыг нээн илрүүлэх, тэдэнд арилжааны данс олгон хамтдаа хөгжиж, дэвших, ашиг хүртэх, амжилтад хүрэх зорилготой бөгөөд энэхүү нөхцөл болон “**Хэрэглэгчийн үйлчилгээний гэрээ**”-ний зүйл заалтууд уг зорилгод нийцсэн байна.
- 1.3. Энэхүү нөхцөл нь Монгол Улсын Иргэний хууль болон эдгээр хуультай нийцүүлэн гаргасан хууль тогтоомжийн бусад актаас бүрдэх ба Монгол Улсын олон улсын гэрээнд өөрөөр заасан бол олон улсын гэрээний заалтыг дагаж мөрдөнө.
- 1.4. “**Хэрэглэгчийн үйлчилгээний гэрээ**”-ний энэхүү хавсралт нь гэрээний адил хүчин төгөлдөр үйлчлэх ба гэрээ болон гэрээний хавсралтад оруулсан нэмэлт, өөрчлөлтүүд нь гэрээний адил хүчин төгөлдөр байна.
- 1.5. Энэхүү “**Үйлчилгээний нөхцөл**” болон “**Хэрэглэгчийн үйлчилгээний гэрээ**”-нд заагдаагүй үйлчилгээний нөхцөл, дүрмийг тухай бүрт нь гаргаж, хэрэглэгчийн цахим шуудан болон өөрийн цахим хуудсаар мэдэгдэнэ.

ХОЁР.НЭР ТОМЪЁО

- 2.1. Энэхүү нөхцөлд дурьдагдах нэр томъёог дараах утгаар ойлгоно. Үүнд:
 - 2.1.1 “**Форекс арилжаа**” гэж олон улсын зах зээл дээрх гадаад валют, үнэт метал, хувьцаа, виртуал хөрөнгө зэрэг хослолийн хөдөлгөөнд арилжаа хийх зах зээлийг;
 - 2.1.2 “**Платформ**” гэж олон улсын зах зээлийн арилжаанд оролцох боломжтой MetaTrader 5, cTrader зэрэг платформыг;
 - 2.1.3 “**Бүртгэл**” гэж <https://www.itrader.global>-д үүсгэсэн бүртгэлийг;
 - 2.1.4 “**Хэрэглэгч**” гэж 18 ба түүнээс дээш насны эрх зүйн бүрэн чадамжтай, олон улсын зах зээлийн арилжаанд MetaTrader 5 платформоор оролцох, өндөр дүнтэй арилжааны дансыг удирдах, мэргэжлийн арилжаачин болох хүсэлтэй, <https://www.itrader.global>-д бүртгэлтэй иргэнийг;
 - 2.1.5 “**Дансны төлбөр**” гэж арилжааны шалгуурын данс худалдан авах төлбөрийг;
 - 2.1.6 “**Шалгуурын данс**” гэж арилжааны платформд нэвтрэх эрхтэй, \$5,000-\$300,000 хүртэлх хэмжээтэй, нэмэлтээр орлого хийх болон зарлага гаргах боломжгүй, тодорхой шалгууртай арилжааны дансыг;
 - 2.1.7 “**Хөшүүрэг**” гэж арилжааны дансны үлдэгдлээр илүү өндөр хэмжээний үнийн дүнд хүрэлцэхүйц арилжаанд орох боломжийг нээж өгдөг хэрэгслийг;
 - 2.1.8 “**Шалгуур**” гэж үйлчилгээ үзүүлэгчээс хэрэглэгчид тавьсан, энэхүү нөхцөлийн 6,7,8 дугаар зүйлд заасан шаардлагыг;
 - 2.1.9 “**Мэргэжлийн арилжаачин**” гэж үйлчилгээ үзүүлэгчийн шалгуурын бүх үе шатанд тэнцсэн, амжилттай, ашигтай ажиллаж буй мэргэжлийн арилжаачийг;
 - 2.1.10 “**Live данс**” гэж энэхүү нөхцөлийн 6,7 дугаар зүйлд заасан шалгуурыг амжилттай хангасан мэргэжлийн арилжаачинд олгох арилжааны жинхэнэ дансыг;
 - 2.1.11 “**Мэдээний үеийн арилжаа**” гэж зах зээлд өндөр нөлөө үзүүлдэг улаан хавтаст буюу high impact төрлийн мэдээг;
 - 2.1.12 “**Амралтын өдрийн арилжаа**” гэж зах зээлийн амралтын өдөр буюу долоо хоног бүрийн бямба, ням гарагийн арилжааг;
 - 2.1.13 “**Алдагдалтай арилжаанд арилжаа нэмэх дүрэм**” гэж алдагдалтай, нээлттэй арилжаанд лотны хэмжээг 2 дахин эсхүл түүнээс дээш хэмжээгээр нэмэгдүүлэх үйдлийг;

- 2.1.14 “**Мартингейл арилжааны стратеги**” гэж нээлттэй арилжаанд лотны хэмжээг 2 дахин эсхүл түүнээс дээш хэмжээгээр удаа дараа нэмэгдүүлэх үйлдлийг;
- 2.1.15 “**Мөрийтэй тоглоомын аргаар арилжаа**” гэж хэрэглэгчийн нээсэн нэг арилжааны алдагдал дансны 2.5%-д хүрэх үйлдлийг;
- 2.1.16 “**Маржин тулгасан арилжаа**” гэж арилжааны дансны маржиныг 100 хувь болон түүнээс дээш хэмжээнд ашигласан үйлдлийг;
- 2.1.17 “**Нээлттэй арилжааны дээд хэмжээ**” гэж энэхүү нөхцөлийн Хавсралт 1.1-т заасан хүснэгтэд тодорхойлсон нээлттэй арилжааны дээд хэмжээг;
- 2.1.18 “**Стоп аут**” гэж маржин түвшин 100% хүрсэн тохиолдолд арилжааг автоматаар хаах үйлдлийг;
- 2.1.19 “**Үйлчилгээний хураамж**” гэж үйлчилгээ үзүүлэгчээс үзүүлсэн үйлчилгээний зардалд тооцож, хэрэглэгчээс суутгах төлбөр;

ГУРАВ.ҮНДСЭН НӨХЦӨЛ

- 3.1. Хэрэглэгч нь энэхүү нөхцөл болон гэрээнд заасан нөхцөлүүдтэй танилцаж, хүлээн зөвшөөрснөөр “**АйТрейдер Финтек**” ХХК-ийн <https://www.itrader.global> веб сайтад бүртгэл үүсгэх, цаашид бидний үйлчилгээг ашиглах эрх үүснэ.
- 3.2. Үйлчилгээ үзүүлэгч нь технологийн шийдлийг ашиглан хэрэглэгчийн Live дансны эрсдэлийг хариуцана.
- 3.3. Хэрэглэгч нь энэхүү нөхцөлийн 4 дүгээр зүйлд заасан дарааллын дагуу өөрийн бүртгэлээ үүсгэх ба “**АйТрейдер Финтек**” ХХК нь энэхүү нөхцөлийн 4.1-т заасан шаардлагыг хангасан хэрэглэгчийг бүртгэнэ.
- 3.4. Хэрэглэгч энэхүү нөхцөлийн 4.1-т заасан шаардлагыг худал мэдүүлсэн тохиолдолд бүх хариуцлагыг хэрэглэгч өөрөө хүлээж, ашгийг хүчингүй болгоно.
- 3.5. Энэхүү нөхцөлд нэмэлт өөрчлөлт оруулах эрх нь зөвхөн “**АйТрейдер Финтек**” ХХК-д байх ба өөрийн цахим хуудсаар дамжуулан нэмэлт, өөрчлөлтийг хэрэглэгчид мэдэгдэнэ.
- 3.6. Энэхүү нөхцөлд нэмэлт өөрчлөлт оруулсан тохиолдолд 6 сар тутамд шинэчлэн батлана.

ДӨРӨВ. БҮРТГЭЛ

4.1. Бүртгэл

- 4.1.1 Хэрэглэгч <https://www.itrader.global> веб сайтад зөвхөн өөрийн овог, нэр, регистрийн дугаар, хүйс, нас, цахим шуудангийн хаяг, утасны дугаар, оршин суугаа газрын мэдээллээр бүртгүүлнэ.
- 4.1.2 Үйлчилгээ үзүүлэгч нь олон улсын ФАТФ-ийн хар болон саарал жагсаалтад багтсан улсын иргэн эсхүл ОХУ-ын иргэнд үйлчилгээ үзүүлэхгүй болно.
- 4.1.3 Дараах шаардлагыг хангасан хэрэглэгчийг бүртгэх болно. Үүнд:
 - 4.1.3.1 Энэхүү үйлчилгээний нөхцөл болон гэрээг хүлээн зөвшөөрсөн;
 - 4.1.3.2 18 ба түүнээс дээш насны эрх зүйн бүрэн чадамжтай;
 - 4.1.3.3 Давхар бүртгэл үүсгээгүй, өөр хүний нэр дээр данс үүсгээгүй;
 - 4.1.3.4 Хувийн мэдээллээ алдаагүй, үнэн зөв, бүрэн бөглөсөн;
 - 4.1.3.5 Компанийн хар жагсаалтанд багтаагүй хэрэглэгчийн бүртгэнэ.

ТАВ. ДАНСНЫ ТӨЛБӨР

- 5.1. Хэрэглэгч өөрийн хэрэгцээнд тулгуурлан 5,000-300,000 ам.долларын шалгуурын дансыг 50-5,000 ам.доллараар худалдан авах боломжтой.
- 5.2. Хэрэглэгч нь үйлчилгээ үзүүлэгчийн шаардлагыг хангаагүй буюу нэг, хоёрдугаар шатны шалгуурт тэнцээгүй тохиолдолд арилжааны шалгуурын дансыг дахин худалдан авах эрх нь үргэлж нээлттэй байна.
- 5.3. Хэрэглэгчийн худалдан авсан идэвхтэй дансны нийт хэмжээ \$600,000 ам.доллараас хэтрэхгүй байх ба хэтрүүлсэн тохиолдолд энэхүү нөхцөлийн 5.2-т заасан нөхцөл үйлчлэхгүй болно.

Буцаан олголт

- 5.4. Хэрэглэгч арилжааны шалгуурын дансыг худалдан авсан өдрөөс хойш 30 хүртэлх хоногийн хугацаанд арилжаа нээгээгүй тохиолдолд дансны төлбөрийг буцаан олгох хүсэлт гаргаж болно.
- 5.5. Хэрэглэгч арилжааны шалгуурын дансыг худалдан авсан өдрөөс хойш арилжаа нээсэн тохиолдолд дансны төлбөрийг буцаан олгохгүй.
- 5.6. Хэрэглэгчийн 3 дахь удаагийн ашиг хуваалтаар анх шалгуурын данс худалдан авсан төлбөрийг 100% буцаан олгоно.
- 5.7. Хэрэглэгч хуваан төлөх нөхцөлөөр худалдан авалт хийгээд арилжаа нээгээгүй тохиолдолд дансны төлбөрийг буцаан олгох хүсэлт гаргаж болох ба бусад нөхцөлд төлбөрийн буцаан олголт хийгдэх боломжгүй болно.

Идэвхгүй байдал

- 5.8. Хэрэглэгч шалгуурын болон Live дансаар 30 ба түүнээс дээш хоногийн хугацаанд арилжаа нээгээгүй тохиолдолд хэрэглэгчийн арилжааны дансыг идэвхгүй болгож, цахим шуудан илгээх ба хэрэглэгч 10 хоногийн дотор хариу өгөөгүй тохиолдолд арилжааны дансыг хааж, дансны төлбөрийг буцаан олгохгүй.
- 5.9. Хэрэглэгч энэхүү нөхцөлийн 5.8-д зааснаар арилжааны Live дансаа хаалгах үед ашигтай байсан тохиолдолд ашгийн 50%-ийг олгож болно.

ЗУРГАА.ПРО ТРЕЙДЕР

6.1. Нэгдүгээр шат - Чадвараа таниулах

- 6.1.1 Хэрэглэгч өөрийн хэрэгцээнд тулгуурлан худалдан авсан шалгуурын дансаар дараах шаардлагыг хангаснаар нэгдүгээр шатанд тэнцэж, хоёрдугаар шатанд оролцох эрхтэй болно. Үүнд:

Дансны төрөл	Swing данс	Standard данс
Хөшүүрэг	1:30 хүртэлх	1:100 хүртэлх
Мэдээний арилжаа	Зөвшөөрнө	Хориотой
Амралтын өдрийн нээлттэй арилжаа	Зөвшөөрнө	Хориотой
Ашгийн шалгуур	Хамгийн багадаа 8 хувийн ашиг олсон байх	
Арилжааны хийсэн байх ёстой хоногийн тоо	3 өдөр	
Нээлттэй арилжааны дээд хэмжээ	Хавсралт 1.1-т заасан	
Өдрийн алдагдлын дээд хязгаар	Нийт /Balance/-ийн 5 хувиас хэтрээгүй байх	Нийт /Equity/-ийн 5 хувиас хэтрээгүй байх
Нийт алдагдлын хязгаар	Худалдан авсан дансны 10 хувиас хэтрээгүй байх	
Арилжааны зардал	1 лот = \$7 байна.	
Стоп аут	100%	

6.2. Хоёрдугаар шат - Мэдлэгээ баталгаажуулах

- 6.2.1 Хэрэглэгч үйлчилгээ үзүүлэгчээс олгосон шалгуурын дансаар дараах шаардлагыг хангаснаар хоёрдугаар шатанд тэнцэж, гуравдугаар шатанд оролцох эрхтэй болно. Үүнд:

Дансны төрөл	Swing данс	Standard данс
Хөшүүрэг	1:30 хүртэлх	1:100 хүртэлх
Мэдээний арилжаа	Зөвшөөрнө	Хориотой

Амралтын өдрийн нээлттэй арилжаа	Зөвшөөрнө	Хориотой
Ашгийн шалгуур	Хамгийн багадаа 5 хувийн ашиг олсон байх	
Арилжааны хийсэн байх ёстой хоногийн тоо	3 өдөр	
Нээлттэй арилжааны дээд хэмжээ	Хавсралт 1.1-т заасан	
Өдрийн алдагдлын дээд хязгаар	Нийт /Balance/-ийн 5 хувиас хэтрээгүй байх	Нийт /Equity/-ийн 5 хувиас хэтрээгүй байх
Нийт алдагдлын хязгаар	Худалдан авсан дансны 10 хувиас хэтрээгүй байх	
Арилжааны зардал	1 лот = \$7 байна.	
Стоп аут	100%	

6.3. Гуравдугаар шат – Про арилжаачин

6.3.1 Хоёрдугаар шатанд тэнцсэн хэрэглэгчийг Үйлчилгээ үзүүлэгчийн зүгээс арилжааны түүх болон хувийн мэдээллийг баталгаажуулан дараах нөхцлөөр хамтран ажиллана. Үүнд:

Дансны төрөл	Live Swing данс		Live Standart данс
Хөшүүрэг	1:30 хүртэлх		1:100 хүртэлх
Мэдээний арилжаа	Зөвшөөрнө		Хориотой
Амралтын өдрийн нээлттэй арилжаа	Зөвшөөрнө		Хориотой
Ашгийн шалгуур	Хамгийн багадаа анх данс худалдан авсан дүнтэй тэнцүү эсхүл түүнээс дээш		
Нээлттэй арилжааны дээд хэмжээ	Хавсралт 1.1-т заасан		
Өдрийн алдагдлын дээд хязгаар	Нийт /Balance/-ийн 5 хувиас хэтрээгүй байх		Нийт /Equity/-ийн 5 хувиас хэтрээгүй байх
Нийт алдагдлын хязгаар	Худалдан авсан дансны 10 хувиас хэтрээгүй байх		
Арилжааны зардал	1 лот = \$7 байна.		
Стоп аут	100%		
Ашиг хуваалтын хугацаа	7 хоног	14 хоног	30 хоног
Шаардлага	1.Хамгийн багадаа 2 өдрийн ашигтай байх	1.Хамгийн багадаа 4 өдрийн ашигтай байх	1.Хамгийн багадаа 6 өдрийн ашигтай байх
	2.Ашгийн хэмжээ хамгийн багадаа тухайн дансны 3%-иас дээш байх	2.Ашгийн хэмжээ хамгийн багадаа тухайн дансны 3%-иас дээш байх	2.Ашгийн хэмжээ хамгийн багадаа тухайн дансны 3%-иас дээш байх
Ашиг хуваалтын хувь	60%	80%	95%

ДОЛОО. ЭКСПЕРТ ТРЕЙДЕР

7.1 Нэгдүгээр шат -Мэдлэгээ баталгаажуулах

7.1.1 Хэрэглэгч үйлчилгээ үзүүлэгчээс олгосон нэг үе шаттай шалгуурын дансаар дараах шаардлагыг хангаснаар нэгдүгээр шатанд тэнцэж, “Эксперт арилжаачин” болно. Үүнд:

Дансны төрөл	Swing данс	Standard данс
Хөшүүрэг	1:30 хүртэлх	1:100 хүртэлх
Мэдээний арилжаа	Зөвшөөрнө	Хориотой
Амралтын өдрийн нээлттэй арилжаа	Зөвшөөрнө	Хориотой

Ашгийн шалгуур	Хамгийн багадаа 10 хувийн ашиг олсон байх	
Арилжааны хийсэн байх ёстой хоногийн тоо	3 өдөр	
Нээлттэй арилжааны дээд хэмжээ	Хавсралт 1.1-т заасан	
Өдрийн алдагдлын дээд хязгаар	Нийт /Balance/-ийн 3 хувиас хэтрээгүй байх	Нийт /Equity/-ийн 3 хувиас хэтрээгүй байх
Нийт алдагдлын хязгаар	Худалдан авсан дансны 8 хувиас хэтрээгүй байх	
Арилжааны зардал	1 лот = \$7 байна.	
Стоп аут	100%	

7.2 Хоёрдугаар шат -Эксперт арилжаачин

7.2.1 Нэгдүгээр шатанд тэнцсэн хэрэглэгчийг Үйлчилгээ үзүүлэгчийн зүгээс арилжааны түүх болон хувийн мэдээллийг баталгаажуулан дараах нөхцлөөр хамтран ажиллана.Үүнд:

Дансны төрөл	Live Swing данс		Standard данс
Дансны хэмжээ	\$300,000 хүртэл		
Хөшүүрэг	1:30 хүртэлх		1:100 хүртэлх
Мэдээний арилжаа	Зөвшөөрнө		Хориотой
Амралтын өдрийн нээлттэй арилжаа	Зөвшөөрнө		Хориотой
Ашгийн шалгуур	Хамгийн багадаа анх данс худалдан авсан дүнтэй тэнцүү эсхүл түүнээс дээш		
Нээлттэй арилжааны дээд хэмжээ	Хавсралт 1.1-т заасан		
Өдрийн алдагдлын дээд хязгаар	Нийт /Balance/-ийн 3 хувиас хэтрээгүй байх		Нийт /Equity/-ийн 3 хувиас хэтрээгүй байх
Нийт алдагдлын хязгаар	Худалдан авсан дансны 8 хувиас хэтрээгүй байх		
Арилжааны зардал	1 лот = \$7 байна.		
Стоп аут	100%		
Ашиг хуваалтын хугацаа	7 хоног	14 хоног	30 хоног
Шаардлага	1.Хамгийн багадаа 2 өдөр ашигтай байх	1.Хамгийн багадаа 4 өдөр ашигтай байх	1.Хамгийн багадаа 6 өдөр ашигтай байх
	2.Ашгийн хэмжээ хамгийн багадаа тухайн дансны 3%-иас дээш байх	2.Ашгийн хэмжээ хамгийн багадаа тухайн дансны 3%-иас дээш байх	2.Ашгийн хэмжээ хамгийн багадаа тухайн дансны 3%-иас дээш байх
Ашиг хуваалтын хувь	60%	80%	95%

НАЙМ.АШИГ ХУВААЛТ

- 8.1. Хэрэглэгч дараах шаардлагыг хангаж, ашиг хуваалтын хугацааг сонгох шаардлагатай. Үүнд:
 - 8.1.1 7 хоногийн дараа ашиг хуваах- Хамгийн багадаа 2 өдөр ашигтай байх, Ашгийн хэмжээ хамгийн багадаа тухайн дансны 3%-иас дээш байх;
 - 8.1.2 14 хоногийн дараа ашиг хуваах- Хамгийн багадаа 4 өдөр ашигтай байх, Ашгийн хэмжээ хамгийн багадаа тухайн дансны 3%-иас дээш байх;
 - 8.1.3 30 хоногийн дараа ашиг хуваах- Хамгийн багадаа 6 өдөр ашигтай байх, Ашгийн хэмжээ хамгийн багадаа тухайн дансны 3%-иас дээш байх.
- 8.2. Хэрэглэгч энэхүү нөхцөлийн 8.1-т заасан ашиг хуваалтын хугацааг сонгосон тохиолдолд дахин өөрчлөх боломжгүй болно.

- 8.3. Хэрэглэгч хамгийн багадаа 5 ба түүнээс дээш удаа ашиг хуваалт хийсэн тохиолдолд Live дансны хэмжээг дараах байдлаар нэмэгдүүлэх хүсэлт гаргаж болно. Үүнд:
- 8.3.1 50%-р дансны хэмжээг нэмэгдүүлэх- Хэрэглэгч хамгийн багадаа 5 удаа ашиг хуваалт хийсэн, ашиг хуваалтын нийт хэмжээ дансны 30%-д хүрсэн тохиолдолд;
 - 8.3.2 100%-р дансны хэмжээг нэмэгдүүлэх- Хэрэглэгч хамгийн багадаа 8 удаа ашиг хуваалт хийсэн, ашиг хуваалтын нийт хэмжээ дансны 50%-д хүрсэн тохиолдолд;
 - 8.3.3 200%-р дансны хэмжээг нэмэгдүүлэх- Хэрэглэгч хамгийн багадаа 10 удаа ашиг хуваалт хийсэн, ашиг хуваалтын нийт хэмжээ дансны 100%-д хүрсэн тохиолдолд;
 - 8.3.4 \$1,000,000 хэмжээтэй данс авах- Хэрэглэгч нь дансны хэмжээнээс үл хамааран хамгийн багадаа 20 удаа ашиг хуваалт хийсэн, ашиг хуваалтын нийт хэмжээ 300,000 ам.долларт хүрсэн тохиолдолд.
- 8.4. Хэрэглэгч нь арилжааны Live дансны өдрийн алдагдлын хэмжээг алдсан боловч дансны үлдэгдэл нь анх авсан Live дансны хэмжээнээс илүү буюу ашигтай байх тохиолдолд дараах шаардлагыг шалгаж, ашгийн 50%-ийг хэрэглэгчид олгох болно. Хэрэв уг шалгуурыг хангаагүй тохиолдолд ашгийг олгохгүй болно. Үүнд:
- 8.4.1 Энэхүү нөхцөл болон “Хэрэглэгчийн үйлчилгээний гэрээ”, “Нууцлалын бодлого”-ыг зөрчөөгүй байх;
 - 8.4.2 10 өдрөөс дээш хугацаанд арилжаа хийсэн байх.

ЕС.АЛДАГДЛЫН ХЭМЖЭЭ

9.1 Өдрийн алдагдлын хэмжээ

- 9.1.1 Өдрийн алдагдлын цагийн шинэчлэлт өвлийн улиралд (Улаанбаатар хотын цагаар өглөөний 06:00AM GMT +8) бусад улиралд (Улаанбаатар хотын цагаар өглөөний 05:00AM GMT +8) байна.
- 9.1.2 Өдрийн алдагдлын хэмжээ нь $\$ = \text{Equity} - (\text{Equity} * 3-5/100)$ -р бодогдоно.
- 9.1.3 Хэрэглэгч шалгуурын дансны өдрийн алдагдлын 3-5 хувийн хэмжээг алдсан тохиолдолд үргэлжлүүлэн арилжаа хийх боломжгүй болно. Хэрэв энэхүү хэмжээг давсан тохиолдолд хэрэглэгчийн арилжаа нээх эрх хаагдаж, цахим шуудангаар мэдэгдэнэ.
- 9.1.4 Хэрэглэгчийн өдрийн алдагдлын хэмжээ нь өдөр бүр энэхүү “Үйлчилгээний нөхцөл”-ийн 09 дүгээр зүйлийн 9.1.1-т заасан хугацаанд шинэчлэгдэнэ.

9.2 Нийт алдагдлын хэмжээ

- 9.2.1 Нийт алдагдлын хэмжээ нь анх эхэлсэн Баланс - Realized & Unrealized P/L бодогдоно.
- 9.2.2 Хэрэглэгч нь шалгуурын дансны нийт хэмжээний 8-10 хувийг алдах боломжтой ба хэрэв энэхүү хэмжээг давсан тохиолдолд хэрэглэгчийн нээлттэй арилжаа автоматаар хаагдаж, цахим шуудангаар мэдэгдэнэ.

АРАВ.ЗӨРЧИЛ

- 10.1 Хэрэглэгч дараах зөрчлийг гаргасан тохиолдолд арилжааны түүхийг хүчингүйд тооцож, ашиг хувиарлах боломжгүй болж, шалгуурын болон Live дансыг хаах болно. Үүнд:
- 10.1.1 Энэхүү үйлчилгээний нөхцөл болон “Хэрэглэгчийн үйлчилгээний гэрээ”, “Нууцлалын бодлого”-ыг зөрчсөн;
 - 10.1.2 Энэхүү нөхцөлийн 1.2-т заасан зорилгод нийцээгүй хэрэглэгчийн үйлдэл, эс үйлдэхүй;
 - 10.1.3 Хэрэглэгч мэдээний үеийн арилжааны дүрмийг зөрчсөн;
 - 10.1.4 Хэрэглэгч амралтын өдрийн арилжааны дүрмийг зөрчсөн;
 - 10.1.5 Хэрэглэгч алдагдалтай арилжаанд арилжаа нэмэх дүрмийг зөрчсөн;
 - 10.1.6 Хэрэглэгч мөрийтэй тоглоомын аргаар арилжих дүрмийг зөрчсөн;
 - 10.1.7 Маржин тулгасан арилжаа хийх дүрмийг зөрчсөн;
 - 10.1.8 Нээлттэй арилжааны дээд хэмжээг зөрчсөн;

- 10.1.9 Хэрэглэгч стоп аут түвшнийг 2 дахь удаагаа зөрчсөн;
- 10.1.10 Энэхүү нөхцөлийн 4.1-т заасан шаардлагыг хангаагүй;
- 10.1.11 Энэхүү нөхцөлийн 5.3-т заасан шаардлагыг хангаагүй;
- 10.1.12 Энэхүү нөхцөлийн 5.8-т заасан шаардлагыг хангаагүй;
- 10.1.13 Хэрэглэгч арилжааны олон дансаар зэрэг арилжаанд оролцох, эсрэг арилжаа нээх;
- 10.1.14 Хэрэглэгч EA болон БОТ, хиймэл оюун ухааны арилжаа AI, өндөр хурдны арилжаа High-Frequency Trading, Гап арилжаа, Сервер спам, Хеджинг зэрэг өөрийн чадварыг ашиглаагүй арилжааны аргаар арилжих;
- 10.1.15 Хэрэглэгч арилжааны Metatrader 5 платформын сул талыг ашиглах, ханшийн хоцрогдлыг ашиглаж арилжаа хийх, 2 дансаар эсрэг арилжаа нээж арилжих;
- 10.1.16 Tick Scalping, Arbitrage, гуравдагч этгээдийн сигналаар арилжих, копи арилжаа, дансаа бусдаар удирдуулах болон бусад ижил төстэй үйлдэл;
- 10.1.17 Энэхүү нөхцөлийн 6.1-7.2-т заасан шалгуурын болон Live дансны дүрмийн зөрчсөн.

Хавсралт 1.

1.Нээлттэй арилжааны дээд хэмжээ

Дансны хэмжээ	Нээлттэй арилжааны дээд хэмжээ
\$5,000	Хязгааргүй
\$10,000	Хязгааргүй
\$25,000	10 лот
\$50,000	20 лот
\$100,000	30 лот
\$200,000	40 лот
\$300,000	50 лот

САНАМЖ

1.Хэрэглэгч та манай веб сайтад бүртгүүлснээр энэхүү "Хэрэглэгчийн үйлчилгээний гэрээ" болон "Үйлчилгээний нөхцөл"-ийг бүрэн хүлээн зөвшөөрсөнд тооцогдоно. Хэрэв та энэхүү гэрээ болон үйлчилгээний нөхцөлтэй санал нийлэхгүй бол өөрийн бүртгэлийг идэвхгүй болгох, гэрээг цуцлах, манай үйлчилгээг бүрэн зогсоох эрхтэй болно.

2.Энэхүү гэрээ болон үйлчилгээний нөхцөлтэй холбоотой асуулт, тодруулах зүйл байвал манай хэрэглэгчийн үйлчилгээний албаны support@itrader.mn цахим шуудангийн хаягаар бидэнтэй холбогдоно уу.

3.Манай "АйТрейдер Финтек" ХХК нь хэрэглэгчтэй албан бус хаягаар харилцах, дансны бүртгэл, нэвтрэх нэр, нууц үг, зэрэг бусад хувийн мэдээллийг шаардахгүй тул мэдээллийн аюулгүй байдлаа сайтар хангаж, цахим залилангийн шинжтэй хууран мэхлэх үйлдлээс урьдчилан сэргийлнэ үү.

4. Манай "АйТрейдер Финтек" ХХК нь "Promo Hunting" буюу үйл ажиллагааг залилан мэхлэх үйлдэл, эс үйлдэхгүйг олж тогтоовол хэрэглэгчийн арилжааны үр дүнг цуцлах, дансыг хаах эрхтэй бөгөөд энэхүү үйлдэл нь бидэнд шууд мэдэгддэг болохыг анхаарна уу.

www.itrader.com
support@itrader.com

Start small, **Grow big.**